



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2022 оны 06 сарын 13-ны
өдрийн 5858 дугаарт бүртгэв.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 08/19

Улаан-Уул

**Малын тоо толгойн албан
татварын хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 63 дугаар зүйлийн 63.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4 дэхь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь;

1. Малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээдийн малын тоо толгойн албан татварын хэмжээг малын төрөл тус бүр дээр дор дурдсанаар тогтоосугай.

Малын төрөл тус бүрт тогтоосон татварын хэмжээ төгрөгөөр				
Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
500	1000	500	500	1200

2. Тогтоолын хэрэгжилтийг хангах, олон нийтэд сурталчилж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат), Татварын улсын байцаагч (Г.Эрдэнэсан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 03/01 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.



Ёсчилсон 2022 оны 06 сарын 03-ны өдөр